



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/337

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх  
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 5 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 670, 2008 оны 133 дугаар захирамжийн хавсралтын 1, 2014 оны А/414 дүгээр захирамжийн хавсралтын 48, 2016 оны А/312 дугаар захирамжийн хавсралтын 145, 2008 оны 88 дугаар захирамжийн хавсралтын 5 дэх заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



488190965

Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны 09 дугаар сарын 24 ны өдрийн  
 1337 дугаар захирамжийн хавсралт

№	Өмчлөгчийн			Өмнөх захирамжийн		Өмнөх газрын		Газрын		
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо дугаар	Холбогдох хэсгийн дугаар	Байршил	Хэмжээ /м2/	Хэмжээ /м2/	Байршил	Үнэ /төгрөг/
1	Даваа	Цэвээнсамбуу	ЗЮ30042002	2008 №133	1	Боржигон 12-10	945	986	Боржигон 16-1623	3155200
2	Соном	Нямзав	ЗЮ54041609	2014 А/414	48	Айраг 4-77	900	594	Партизан 3-306	1900800
3	Мөнгөн-Эрдэнэ	Намуунаа	ЗЮ12282707	2016 А/312	145	Аривжих 11-17	1000	1182	Аривжих 12-1235	3782400
4	Дулмаа	Өлзийт	ЗК54010501	2005 №319	670	Айраг 2-306	905	998	Айраг 1-169	3193600
5	Цэрэнжид	Дамба	ЗК54121518	2008 №88	5	Мандал 16-7	600	682	Мандал 18-1812	2182400